

БАТЛАВ.
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА *М. Чиритийн* ЦЭРДЭМБИЛЭГ

**ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭЛИЙН ШИНЖЭЭЧ СОНГОН ШАЛГАРУУЛНА.**

Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.2.4 дэх заалт, 2017 оны "Магадлан итгэмжлэлийн шинжээч сонгон шалгаруулж, томилох, чөлөөлөх журам батлах тухай" А/118 дугаар тушаалаар батлагдсан журамд заасны дагуу Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн орон тооны бус шинжээчийн сонгон шалгаруулалтад урьж байна.

Тавигдах шаардлага

1. Тухайн мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил тасралтгүй ажилласан;
2. Анагаах ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, мэргэшлийн зэрэг эсхүл эрдмийн цолтой;
3. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах, баримт бичиг боловсруулах чадвар, дадлага туршлагатай;
4. Эмнэлгийн удирдлага, тусlamж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын чиглэлээр гадаад, дотоодод урт, богино хугацааны сургалтад хамрагдаж байсан, судалгаа шинжилгээний ажил хийж байсан туршлагатай;
5. Тасаг, нэгжийн эрхлэгчээс дээш удирдах албан тушаал эрхэлдэг эсвэл удирдаж байсан туршлагатай;
6. Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага (эмнэлэг, сувилал, эм хангамжийн байгууллага)-д захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүний албан тушаал эрхэлдэггүй;
7. Цахим орчин, компьютерийн хэрэглээний програм хангамж саадгүй ажиллах чадвартай байх;
8. Ес зүй, харилцаа, хандлагын зөрчил гаргаж байгаагүй;
9. Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй;

Дээрх шаардлагыг хангасан дараах мэргэжлээр мэргэшсэн мэргэжилтэн сонгон шалгаруулалтад оролцно. Үүнд:

- Арьс судлал
- Гэмтэл согог судлал
- Дотрын анагаах судлал
- Дурс оношилгоо судлал
- Мэдрэл судлал
- Мэдээгүйжүүлэг судлал
- Мэс засал судлал
- Нүд судлал
- Өрхийн анагаах судлал
- Сувилахуй судлал
- Сэтгэц судлал

- Чих хамар хоолой судлал
- Эрчимт эмчилгээ судлал
- Эх барих эмэгтэйчүүд судлал
- Эмнэл зүйн эмгэг судлал
- Эм зүй, клиник эм зүй судлал
- Сэргээн засал судлал
- Нуур ам судлал
- Уламжлалт анагаах ухаан судлал
- Тоног төхөөрөмжийн инженер
-

Бүрдүүлэх баримт бичиг:

1. Өргөдөл
2. Төрийн албан хаагчийн анкет
3. Иргэний цахим үнэмлэхийн хуулбар
4. Дээд боловсролын диплом, мэргэжлийн үнэмлэх, удирдлагын сургалтын гэрчилгээ, судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт, эрдмийн цол болон мэргэшлийн зэргийг нотлох баримтыг нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
5. Эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгөх, багаар ажиллах чадвартай, ажлын дадлага туршлага, тасралтгүй сургалтад хамрагдсан талаарх ажиллаж буй байгууллага, мэргэжлийн салбар зөвлөл, нийгэмлэгийн тодорхойлолт;
6. Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл (УИХ-ын хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан маягтаар)
7. 3x4 хэмжээтэй 2 хувь зураг
8. Ёс зүйн салбар хорооны тодорхойлолт
9. Эрүүл мэндийн байгууллагад ажилладаг нэр дэвшигч нь тухайн байгууллагын удирдлагаас шинжээчээр ажиллахад татгалзах зүйлгүй талаар алба бичиг

Сонгон шалгаруулалтад оролцох мэргэжилтний баримт бичгийг Эрүүл мэндийн яамны бичиг хэрэгт 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 17.00 цаг хүртэл хүлээж авна.

Сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллийг 51-263757 дугаарын утсаар лавлана уу.